



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/727

Ховд


Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймгийн Буянт сумын Цагаан эрэг багийн Засаг дарга М.Кистаувайг огцруулах тухай Ховд аймгийн Буянт сумын Засаг дарга М.Пүрэвийн 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн Б/11 дугаартай захирамж нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2, 32.4 дэх хэсэгт заасан “Засаг даргыг тухайн шатны хурал огцруулах эсэх саналаа хүргүүлнэ” гэснийг зөрчиж тухайн шатны хурлын саналыг аваагүй байх тул Буянт сумын Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн Б/11 дугаартай захирамжийг хүчингүй болгосугай.

2.Захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг Буянт сумын Засаг дарга М.Пүрэвд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ